



**“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ГАЛ УНТРААХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН  
МАШИН НИЙЛҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН  
САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,  
шаардлага**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн санал, дүгнэлт, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дүгээр сарын 05-ны өдрийн 163 дугаар захирамжийг үндэслэн “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан.

"Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

**Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд "Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

**Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

"Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд гал түймрийн хөөсөөр унтраах автомашин худалдан авч, аюулт үзэгдэл, гал түймэр унтраах үйл ажиллагааг сайжруулах чухал ач холбогдолтой юм.

**Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.